



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯНХУТАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 01 өдөр

Дугаар A/94

Баянхутаг сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалт, 33 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулалт явуулах журам”-ын 11.10 дахь хэсэг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны “2024 оны Газар зохион байгуулах төлөвлөгөө батлах тухай” 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Засаг даргын 2024 оны A/52 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтад ялагч болсон малчдын хоршоонд мал аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалтаар эзэмшүүлэх газрын байршил, хэмжээг хавсралтаар баталсугай.

Малчдын хоршоонд эзэмшүүлсэн нэгж талбарыг газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд бүртгэж, газар эзэмших эрхийн эд хөрөнгийн улсын бүртгэлд бүртгүүлж, газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, гэрчилгээг баталгаажуулахыг Газрын даамал (Т.Наранбаяр)-т үүрэг болгосугай.

Газрын гэрээнд заасан нөхцөл, болзлын хүрээнд зориулалтын дагуу ашиглаж, газрын төлбөрийг хугацаанд төлөхийг газар эзэмшигч малчдын хоршоонд даалгасугай.

ДАРГА

Б.АМГАЛАНБАТ

Сумын Засаг даргын 2024 оны 02 дугаар
сарын 01 өдрийн 1194 тоот захирамжийн
01 тоот хавсралт



Эзэмшүүлэх газрын байршил, хэмжээ, зориулалт, хугацаа

№	Газар эзэмшигчийн нэр (хоршоо)	Регистрийн дугаар	Төлөвлөлтийн нэгж талбарын дугаар	Хэмжээ	Зориулалт	Хаяг	Эзэмшүүлэх хугацаа
1	Амин шимт нэгдэл	4211685	4091945	5га	Мал аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалт	Хаялагат петровис колонкын баруун урд	15 жил
2	Өнө Дэлгэрэх рашаант	4212509	4105990	5га	Мал аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалт	Хаялагат Хэрлэн зоогийн зүүн талд	15 жил
3	Баян хайрхан дэнж	4191927	4092214	5га	Мал аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалт	Хаялагат хангарьд колонкын замын урд	15 жил
4	Мөнх дэлгэрэх хаяа	4209494	4105987	5га	Мал аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалт	Хаялагат петровис колонкын баруун урд	15 жил
5	Их төхөмийн хүйс	4209885	4105988	5га	Мал аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалт	Хаялагат петровис колонкын баруун урд	15 жил
6	Голын эрзэн	4208455	4105989	5га	Мал аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалт	Хаялагат петровис колонкын баруун урд	15 жил